
NEAR Холбооны Ажлын хэсгийн хорооны 12-р хурлын тайлан

- Хугацаа : 2019.08.06 ~ 08.08
- Болсон газар : ОХУ-ын Сахагийн БНУ-ын Якутск хот, Засгийн газрын 1-р ордон
- Зорилго : Санал асуудлыг хэлэлцэх, гишүүн орон нутгуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх



Зүүн хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооны Хэрэг эрхлэх газар
(The Secretariat of the Association of Northeast Asia Regional Governments)

「NEAR Холбооны Ажлын хэсгийн хорооны 12-р хурал」 -ын тайлан

Гишүүн орон нутаг хооронд ЗХАНЗХ(NEAR)-ны гол үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцохын зэрэгцээ хуралд тавигдах санал асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

Арга хэмжээний тойм

- Хугацаа : 2019.08.06~08.08, 2 хоног 3 өдөр
- Болсон газар : ОХУ-ын Сахагийн БНУ-ын Якутск хотын Засгийн газрын 1-р ордон
- Зохион байгуулагч : ЗХАНЗХ(NEAR)/-ны тэргүүлэгч орон нутаг
- Оролцсон : 79 хүн (4 улсын 19 гишүүн орон нутгийн 66 хүн, NEAR ХЭГ-ийн 13 хүн)

※ Бичгээр шийдвэрээ өгсөн : 5 улсын 30 гишүүн орон нутаг

Улс	Оролцсон	Орон нутгийн нэр
БНХАУ	6 орон нутаг, 15 хүн	Хэнан муж, Хэйлонжан муж, Хубэй муж, Өвөрмонголын ӨЗО, Ниншягийн хотон үндэстний ӨЗО, Шаньдун муж
Япон улс	3 орон нутаг, 8 хүн	Тояама муж, Хёго муж, Шиманэ муж
БНСУ	7 орон нутаг, 17 хүн	Гванжү хот, Ульсан хот, Гёнги муж, Чүнчоннам муж, Жолланам муж, Гёнсанбүг муж, Гёнсаннам муж
ОХУ	3 орон нутаг, 26 хүн	Сахагийн БНУ, Красноярск хязгаар, Амур муж

Гол агуулга

- **Холбооны гол үйл ажиллагааны тайлан**
 - Холбооны ХЭГ-ийн үйл ажиллагааны тайлан
 - NEAR Холбооны 12-р Бүгд хурлын тайлан (бичгээр)
 - Салбар хороодын үйл ажиллагааны тайлан (Тояама муж, Хёго муж)
 - Залуу удирдагч форумын үйл ажиллагааны тайлан (Красноярск хязгаар)
- **Гишүүн орон нутгуудын илтгэл** (Хэнан муж, Шаньдун муж, Гванжү хот, Гёнсанбүг муж, Амур муж)
- **Ажлын хэсгийн хорооны санал хэлэлцүүлэг**
 - Холбооны арга хэмжээ зохион байгуулах арга барилыг сайжруулах тухай санал
 - Гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах санал
 - Гишүүн орон нутаг бүрээр хүндэт элч томилох санал
 - 2020 оны Холбооны ХЭГ-ийн гол арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах,

төлөвлөгөөний талаар гишүүн орон нутгуудын саналыг авах

- Холбооны 14 дэх тэргүүлэгч болох орон нутгийн хүсэлт авах

- Холбооны ХЭГ-ийн төсвийн тайлан

◦ **Хотгой танилцах аялал** (Юнескогийн өвд бүртгэлтэй Лена мөрний чулуун баганат байгалын цогцолбороор аялах

Хөтөлбөр

Өдөр	Цаг	Гол агуулга	Тайлбар
08.06	NEAR Холбооны Биеийн тамирын хорооны 1-р хурал, 'Нийтийн төв' 6 давхарт		
	14:30~17:45	◦Нээлтийн үг ◦'NEAR Холбооны үндэсний спортын фестиваль'-ийн тухай илтгэл ◦'Хуралд оролцогч орон нутгуудын үндэсний спорт'-ын тухай илтгэл	Хөтлөгч : Сахагийн БНУ
	17:45~18:00	◦Сахагийн сонин, телевизд ярилцлага өгөх	
	18:00~19:00	◦Хөдлөх (Олон нийтийн төв ⇒ Зочид буудал (Амрах) ⇒ Хүлээн авалтын танхим)	
	19:00~20:30	◦Хүлээн авалт	Севенс Хэбэн ресторан
	20:30~	◦Хөдлөх (Хүлээн авалтын танхим ⇒ Зочид буудал), чөлөөт цаг	
08.07	NEAR Холбооны Ажлын хэсгийн хорооны 12-р хурал 'Нийтийн төв' 6 давхарт		
	07:00~08:00	◦Өглөөний хоол	Зочид буудал
	08:00~08:30	◦Хөдлөх (Зочид буудал ⇒ Арга хэмжээний газар 'Нийтийн төв')	
	08:30~09:00	◦Хуваарилсан суудалд суух	NEAR Холбооны видео танилцуулга
(Нээлтийн ажиллагаа)			

09:00~10:00	<p>◦Нээлтийн ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> - Сахагийн БНУ-ын төрийн тэргүүний мэндчилгээ - NEAR Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын мэндчилгээ -“Сахагийн БНУ-ын хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын боломж” илтгэл - Дурсгалын зураг авахуулах 	Хөтлөгч : Сахагийн БНУ
10:00~10:30	◦Coffee Break	
(Ажлын хэсгийн хорооны хурал. I -р хэсэг)		
10:30~12:30	<p>◦Оролцогчдыг танилцуулах</p> <p>◦NEAR Холбооны үйл ажиллагааны тайлан</p> <ul style="list-style-type: none"> - NEAR Холбооны Хэрэг Эрхлэх Газрын үйл ажиллагааны тайлан - NEAR Холбооны 12-р Бүгд хурлын тайлан - Байгаль орчны хорооны тайлан (Япон улс, Тояма муж) - Гамшгаас сэргийлэх хорооны тайлан (Япон улс, Хёго муж) - Залуу удирдагч форумын тайлан (ОХУ, Красноярск хязгаар) <p>◦Гишүүн орон нутгуудын илтгэл</p> <ul style="list-style-type: none"> - БНХАУ(Хэнан муж) - БНСУ(Гванжү хот, Гёнсанбүг муж) 	Хөтлөгч : Сахагийн БНУ
12:30~13:00	◦Хөдлөх (Арга хэмжээний газар‘Нийтийн төв’ ⇒ Ресторан)	
13:00~14:00	◦Өдрийн хоол	
14:00~14:30	◦Хөдлөх (Ресторан ⇒ Арга хэмжээний газар‘Нийтийн төв’)	
(Ажлын хэсгийн хорооны хурал. II-р хэсэг)		

	14:30~16:30	<p>◦Хурлын илтгэл хэлэлцүүлэг</p> <ul style="list-style-type: none"> - Санал 1: Холбооны арга хэмжээ зохион байгуулах арга барилыг сайжруулах тухай - Санал 2: Гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах - Санал 3: Гишүүн орон нутаг бүрээр NEAR-ыг сурталчлах хүндэт элч томилох - Санал 4: 2020 онд болох NEAR ХЭГ-ийн төлөвлөгөөг танилцуулах болон төлөвлөгөөтэй холбогдуулан гишүүн орон нутгуудын саналыг авах - Тайлан 1: NEAR Холбооны 14 дэх тэргүүлэгчийн хүсэлт хүлээж авах - Тайлан 2: 2018 оны NEAR ХЭГ-ийн төсвийн тайлан 	Хөтлөгч : NEAR ХЭГ
	16:30~18:00	<p>◦Хурлын дүгнэлт гаргах</p> <ul style="list-style-type: none"> ◦Хурлын дүгнэлтийг танилцуулах ◦Хаалтын ажиллагаа 	
	18:00~19:00	◦Хөдлөх (Арга хэмжээний газар‘Нийтийн төв’ ⇒ Зочид буудал (Амралт) ⇒ Хүлээн авалтын танхим)	
	19:00~20:30	◦ Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авч зоог барина.	Мүүс Хайяа ресторан
08.08	07:00~08:00	◦Өглөөний хоол	Зочид буудал
	08:00~12:00	◦Хөдлөх (Зочид буудал ⇒ Лена мөрний чулуун баганат байгалийн цогцолбор)	Аялагчийн усан онгоц
	12:00~13:00	◦Лена мөрний чулуун баганат байгалийн цогцолбороор аялах	
	13:00~14:00	◦Өдрийн хоол	
	14:00~18:00	◦Хөдлөх (Лена мөрний чулуун баганат байгалийн цогцолбор ⇒ Зочид буудал)	
	18:00~19:00	◦Оройн хоол	
	19:00~	◦Чөлөөт цаг, нутаг буцах	



Гол үйл ажиллагааны тайлан

Ангилал	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	Улс	Харьяа, албан тушаал
Холбооны гол үйл ажиллагааны тайлан	NEAR ХЭГ-ийн үйл ажиллагааны тайлан	Ким Ён Хи	NEAR	Төлөвлөлт, Олон нийттэй харилцах хэлтсийндарга
	NEAR Холбооны 12-р Бүгд хурлын тайлан	Бичгээр тайлагнана	БНХАУ	Хунан муж
Салбар хороодын тайлан	Байгаль орчны хорооны хурал	Какизава Масахиро	Япон улс	Тояама мужийн Нэгдсэн бодлогын газрын дэд дарга
	Гамшгаас сэргийлэх хорооны хурал	Юүкугава Хүтоши	Япон улс	Олон улстай харилцах хэлтсийн дарга
Залуу удирдагч форумын тайлан		Руман Минкин	ОХУ	Красноярск хязгаарын Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн зөвлөх
Гишүүн орон нутгуудын илтгэл		Ян Вэйбин	БНХАУ	Гадаад харилцааны газрын ажилтан
	Хүний эрхийн хот Гванжү ба олон улсын хамтын ажиллагаа	Ким Гван Хүй	БНСУ	Гванжү хотын Төлөвлөлт, зохицуулалтын албаны дарга
	NEAR Холбооны Эдийн засаг, хүмүүнлэгийн харилцааны хорооны 13-р хурлын төлөвлөгөө/Гёнжү 2019 –Дэлхийн соёлын экспоны зар	Ким Ху Жин	БНСУ	Гёнсанбүг мужийн Ажлын байр, Эдийн засаг, Аж үйлдвэрийн албаны дарга



Гол хэлэлцсэн асуудал

Хурлаар хэлэлцэх асуудал, санал хэлэлцүүлэг	Холбооны арга хэмжээг зохион байгуулах арга барилыг өөрчлөх тухай	Пак Сон Мин Олон улс, хамтын ажиллагааны хэлтсийн дарга	NEAR	Холбооны арга хэмжээг зохион байгуулах арга барилыг сайжруулах тухай саналын заримыг хүлээн зөвшөөрч цаашид арга хэмжээ зохион байгуулахад зарчим болгохоор болсон.
	Гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах	Ким Ён Хи Төлөвлөлт, Олон нийттэй харилцах хэлтсийн дарга	NEAR	Гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах тухай саналыг гишүүн орон нутгууд дэмжсэн ба гишүүний татварын журмын агуулгад өөрчлөлт оруулсан.
	Гишүүн орон нутаг бүрээр NEAR Холбоог сурталчлах элч томилох			Гишүүн орон нутаг бүрээр хүндэт элч томилох саналыг нэвтрүүлэхээр болсон бөгөөд хойшид Холбооны Хэрэг эрлэх газраас дэлгэрэнгүй мэдээллийг гишүүн орон нутгуудад бичгээр хүргэхээр тохиролцсон.
	2020 Холбооны Хэрэг эрхлэх газрын төлөвлөгөөг танилцуулах болон төлөвлөгөөний талаар гишүүн орон	Пак Сон Мин Олон улс, Хамтын ажиллагааны хэлтсийн дарга	NEAR	Холбооны Хэрэг эрхлэх газраас гишүүн орон нутгуудын саналыг нааштай хүлээн авч дараа жилийн үйл ажиллагаанд тусгахаар болсон.

	нутгуудын саналыг авах;			
	Холбооны 14 дэх тэргүүлэгч болох орон нутгийн хүсэлт хүлээж авах	Ким Уг Чэ Ерөнхий нарийн бичгийн дарга	NEAR	Хурлаар Холбооны дараагийн тэргүүлэгч болох хүсэлтэй орон нутаг байгаагүй тул энэ асуудлыг алгассан.
	NEAR ХЭГ-ийн 2018 оны төсвийн тайлан	И Вон Ён Төлөвлөлт, Олон нийттэй харилцах хэлтсийн багийн ахлагч	NEAR	Холбооны Хэрэг эрхлэх газрын төсвийн зарцуулалтын талаар дэлгэрэнгүй тайлагнасан.
Тэргүүлэгч орон нутгийн санал	NEAR-ын гишүүн орон нутаг хооронд танилцуулга тавих	Гаврил Криллин Сахагийн БНУ-ын гадаад харилцаа, Үндэсний хэргийн яамны сайд	ОХУ	2020 оны 13-р Бүгд хурлаар бизнес, эдийн засгийн хамтын ажиллагааны зорилгоор хөрөнгө оруулалт, экспорт, аялал жуулчлалын талаар NEAR-ын гишүүн орон нутгуудаар илтгэл тавиулах санал

※ Хавсралт : NEAR Холбооны Ажлын хэсгийн хорооны 12-р хурлын дүгнэлт



Гол хэлэлцсэн асуудал

1. (Санал 1) Холбооны арга хэмжээг зохион байгуулах арга барилыг сайжруулах тухай санал

Саналын үндэслэл агуулгыг тайлбарласан (NEAR ХЭГ)

Гишүүн орон нутгуудаас хэлсэн үг, асуулт хариулт

Гишүүн орон нутаг	Гол агуулга
БНСУ, Гванжү хот	Санал 1 нь бодит зүйл тул тусгай хэлэх санал алга.

<p>Япон улс, Тояама муж</p>	<p>·Санал 1-ийн үндсэнд нь дэмжиж байна.</p> <p>Гэхдээ 78 гишүүн орон нутаг бүр ажлын арга барил өөр тул тухайн орон нутгийн бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч ойлгох юм бол NEAR-ын арга хэмжээнд оролцох оролцоо нэмэгдэнэ.</p> <p>. NEAR Холбооны арга хэмжээг бүхэлд нь бус Бүгд хурал, Ажлын хэсгийн хорооны хурал, Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, Олон улсын форум зэргийг Холбооны Хэрэг эрхлэх газраас, салбар хорооны арга хэмжээг тухайн хариуцсан орон нутаг хариуцан ажиллах байдлаар шийдэх хэрэгтэй.</p> <p>Дээрх арга хэмжээнүүдээс салбар хорооны хурлыг тухайн хороог зохицуулагч орон нутаг явуулдаг тул хурал, арга хэмжээ зохиохоос дор хаяж 3 сарын өмнө урилга албан бичгийг явуулах ёстой гэх мэт хүчилж шаардахгүйгээр тухайн орон нутагт нь бие даасан байдлыг нь өгөхийг хүсч байна.</p>
<p>NEAR Хэрэг эрхлэх газар</p>	<p>·NEAR Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны зарчим нь хүчээр тулгаж буй шаардлага бус зөвхөн санал болгосон зүйл бөгөөд салбар хорооны хурал арга хэмжээ зохион байгуулах талын бие даасан байдал бүрэн хангагдсан.</p> <p>·Зарим орон нутаг Салбар хорооны хурлыг зохиохоор төлөвлөөд 1 сарын өмнө буюу хугацаанд тулгаж хурлын зар, урилгыг явуулснаас оролцох хүмүүс бага болох зэргээс үүдэн арга хэмжээг зохиоход хүндрэлтэй байдаг.</p> <p>· Иймд арга хэмжээ зохион байгуулах арга барилыг сайжруулах тухай саналын үндсэн зарчмыг чиг болгож салбар хороодын үйл ажиллагааг уян хатан болгоно.</p>

Санал 1-ын талаар гаргасан шийдвэр.

- 49 гишүүн орон нутаг (бичгээр шийдвэр ирүүлсэн 30 гишүүн орон нутаг) бүгд саналыг дэмжсэн.

2. (Санал 2) Гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах тухай санал

Саналын үндэслэл болон агуулгыг тайлбарласан (NEAR Хэрэг эрхлэх газар)

Санал 2-ыг

- 49 гишүүн орон нутаг (бичгээр шийдвэр ирүүлсэн 30 гишүүн орон нутаг)-аас 46 нь дэмжсэн (бичгээр дэмжих санал өгсөн 27), дэмжихгүй гэсэн саналтай 3 нутаг (бичгээр 3)

3. (Санал 3) Гишүүн орон нутаг бүрээр NEAR-ыг сурталчлах хүндэт элч томилох санал

Саналын үндэслэл, агуулгыг тайлбарласан (NEAR Хэрэг эрхлэх газар)

Гишүүн орон нутгуудаас саналын талаар хэлсэн үг

Гишүүн орон нутаг	Гол агуулга
Япон улс, Хёго муж	·NEAR-ын нэр хүндийг дээшлүүлэх үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж байна. Гэхдээ орон нутгаас ямар хүнийг элчээр томилж өргөмжлөх талаар тодорхой хэмжүүр байхгүй байна. Иймд энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгөхийг хүсье.
NEAR Хэрэг эрхлэх газар	·Юуны өмнө хүндэт элчид өргөмжлөхөд цалин, хөлс олгогдохгүй. ·Зөвхөн NEAR Хэрэг эрхлэх газрын төсвөөр 1 жилд 1 удаа урин Холбооны үйл ажиллагаанд оролцуулна. ·Хүндэт элчээр томилогдвол орон нутагтаа NEAR Холбоог сурталчлан таниулах болон NEAR-ын арга хэмжээнд хувийн зардлаар оролцох боломжийг олгоно. ·Санал 3-ын талаар тодорхой төлөвлөгөө гарган гишүүн орнуудад мэдэгдэх болно.
Япон улс, Шиманэ муж	·Хүндэт элч томилох нь их чухал хэрэг юм. ·Орон нутаг бүр өөрсдийн сурталчилгааны материалд NEAR-ын талаар танилцуулан NEAR-ыг сурталчлах үйл ажиллагааг орлуульж болох юм.

Санал 3-ыг

- 49 орон нутаг (Бичгээр шийдвэр ирүүлсэн 30 гишүүн орон нутаг) –аас 42-нь дэмжсэн (бичгээр 23), дэмжээгүй 7 (бичгээр 7)

4. (Санал 4) 2020 оны NEAR Хэрэг эрхлэх газрын гол арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах, төлөвлөгөөний талаар гишүүн орон нутгуудын саналыг авах

Саналын үндэслэл, агуулгыг тайлабрласан (NEAR Хэрэг эрхлэх газар)

Саналын агуулга, гишүүн орон нутгуудаас саналын талаар хэлсэн үг

Гишүүн орон нутаг	Гол агуулга
NEAR Хэрэг эрхлэх газар	·2020 оны NEAR Хэрэг эрхлэх газрын гол арга хэмжээний төлөвлөгөөнд NEAR Олон улсын форумыг усан замын аялал жуулчлал сэдвээр зохиох талаар судалж байгаа бөгөөд гишүүн орон нутгуудаас өөр санал болгох сэдэв байвал тухайн сэдвээр зохиох боломжтойг танилцуулсан.
БНХАУ, Хэнан муж	·NEAR Хэрэг эрхлэх газраас санал болгосон олон улсын форум зэрэг 4 арга хэмжээ бүгд чухал тул уг саналыг дэмжиж байна.

Санал 4-ийг

- 49 гишүүн орон нутаг

(бичгээр санал өгсөн 30 гишүүн орон нутаг) –аас 49 орон нутаг дэмжсэн.

5. (Тайлан 1) Холбооны 14-дэх тэргүүлэгч болох орон нутгийн хүсэлт авах

Харамсалтай нь энэ удаад Холбооны 14 дэх тэргүүлэгч болох хүсэлтэй орон нутаг байхгүй тул уг тайланг алгассан.

6. (Тайлан 2) 2018 оны NEAR Хэрэг эрхлэх газрын төсвийн дэлгэрэнгүй тайлан

NEAR Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны зардлын тайлан

※ 2005 оноос хойш тус газрын үйл ажиллагааны зардлыг гаргаж буй Гёнсанбүг мужид алга ташиж талархал илэрхийлсэн.



Ажлын хэсгийн хорооны хурлын дүгнэлт

Ерөнхий
дүгнэлт

<Сайн тал>

- Холбооны тэргүүлэгч орон нутгаас Ажлын хэсгийн хорооны хурал болон Биеийн тамирын хорооны хурлыг хамт зохион байгуулснаар Биеийн тамирын хорооны хуралд оролцох орон нутгийн оролцоог нэмэгдүүлсэн (4 улсын 8 гишүүн орон нутаг) ба хажуугаар нь Сахагийн үндэсний спортыг сурталчлах өндөр үн дүнтэй байсан.
- Сахагийн БНУ-ын Засгийн газраас зочид буудлаас нисэх онгоцны буудал хооронд зочдыг үдэж тоссон нь хуралд оролцогчдын тав тухыг хангасан.
- Хэрэг эрхлэх газраас синхрон орчуулагчид урьдаас хурлын дэлгэрэнгүй сценарыг орчуулан өгснөөр хурлын санал хэлэлцүүлэг саадгүй явагдсан.
- Ерөнхий нарийн бичгийн дарга Ким Уг Чэ Сахагийн хамгийн том телевизийн компани болох Якут телевизд ярилцлага өгч NEAR-ын талаар танилцуулж сурталчилсан.
- NEAR-ын Хэрэг эрхлэх газраас 2005 оноос БНСУ-ын Гёсанбүг мужаас Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагаанд зарцуулсан нийт зардлын дүн ба 2018 оны тус газрын төсвийн зарцуулалтын талаар дэлгэрэнгүй танилцуулсан бөгөөд гишүүн орон нутгууд Гёсанбүг мужид алга ташин талархал илэрхийлсэн.

Ерөнхий
дүгнэлт

<Засч сайжруулуштай зүйл>

- Ажлын хэсгийн хорооны хурал болохын өмнө хуралд оролцохгүй гэдгээ цагийг нь тулгаж мэдэгдсэн орон нутаг их байсан бөгөөд ялангуяа Монголын орон нутгууд бүгд оролцоогүй нь харамсалтай байсан.
→ Холбооны арга хэмжээний бэлтгэлийг хангахад гишүүн орон нутгуудын дэмжлэг хэрэгтэй бөгөөд гишүүн орон нутгуудын хуралд оролцох оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Үргэлж гардаг орчуулгын чанарын асуудлыг шийдэхийн тулд Холбооны Хэрэг эрхлэх газраас урьдаас хурлын сценарыг орчуулагчдад өгч зарим асуудлыг шийдсэн ч хурлын хэлэлцүүлгийн үеэр орчуулагчийн чадвараас шалтгаалан хэлэлцүүлгийн санааг тодорхой ойлгуулахад бэрхшээлтэй байсан.
→ Цаашид уг асуудлыг үндсээр нь шийдэх арга замыг хайх хэрэгтэй.
- Якутскийн нисэх онгоцны буудал нь олон улсын шууд нислэг бараг байхгүй тул хуралд

оролцогчдын ихэнх нь Владивосток, Новосибирскээр дамжиж ирсэн нь бэрхшээлтэй, цаг их шаардагдсан.

→ 2020 онд зохиох 13-р Бүгд хурлыг болж өгвөл олон улсын шууд нислэгтэй тааруулан хурлыг зохиох талаар тэргүүлэгч орон нутаг судлах хэрэгтэй.

◦ Ажлын хэсгийн хороо нь гишүүн орон нутгуудын тамгын газрын дарга нараас бүрдэнэ гэж заасан байдаг ч бодит байдалд Ажлын хэсгийн хороо гэдэг нэрээс харахад мэргэжилтнүүд хуралд оролцоно гэсэн ойлголттой байдаг тул орон нутгийн удирдлагууд оролцох нь бага байна.

→ Иймд 2021 оны Ажлын хэсгийн хорооны хурлын зар албан бичигт Ажлын хэсгийн хорооны хуралд удирдах албан тушаалтан оролцоно гэж заах нь зүйтэй.

◦ Энэ удаагийн Ажлын хэсгийн хорооны хуралд 78 гишүүн орон нутгаас 19 гишүүн орон нутаг л оролцсон бөгөөд хурлын санал шийдвэр гаргахад бүрдэх тоонд хүрэхийн тулд хуралд биечлэн ирж оролцоогүй орон нутгуудаас бичгээр санал шийдвэр авч байгаа ч Холбооны Үндсэн дүрэмд бичгээр шийдвэр авна гэсэн заалт байхгүй юм.

→ Иймд 2020 оны Бүгд хуралд Холбооны Үндсэн дүрэмд бичгээр шийдвэр авна гэсэн заалт (9-р зүйл. Шийдвэр гаргах) шинээр оруулж бичгээр санал өгснийг хуралд оролцож санал өгснөөр тооцох ёстой.

Арга хэмжээний үеэрх зураг



Өдөр	2019.08.07	Тайлбар	Хуралд оролцогчид дурсгалын зураг авахуулав
------	------------	---------	---



Өдөр	2019.08.07	Тайлбар	Хурлын үеэр
------	------------	---------	-------------



Өдөр	2019.08.07	Тайлбар	Хурлыг Ерөнхий нарийн бичгийн дарга, Сахагийн Ерөнхий сайд хамтран хөглөв.
------	------------	---------	--



Өдөр	2019.08.07	Тайлбар	Якутын 24 TV-д Ерөнхий нарийн бичгийн дарга ярилцлага өгөв.
------	------------	---------	---

【Хавсралт】

NEAR Холбооны Ажлын хэсгийн хорооны 12-р хурлын дүгнэлт

2019 оны 8-р сарын 7-ны өдөр ОХУ-ын Сахагийн БНУ-д болсон ЗХАНЗХ-ны Ажлын хэсгийн хорооны 12-р хуралд БНХАУ, Япон, БНСУ, ОХУ зэрэг 4 улсын 19 орон нутгийн төлөөлөл оролцсон бөгөөд бичгээр шийдвэрээ ирүүлсэн 30 орон нутаг нийт 49 орон нутаг шийдвэр гаргахад оролцсон.

Хурлын нээлтийн ажиллагааны дараа эхэлсэн хурлын 1-р хэсэгт ЗХАНЗХ-ны ХЭГ-ийн үйл ажиллагааны тайлан, 12-р Бүгд хурлын тайлан, Япон улсын Тояама, Хёго муж салбар хорооны тайланг тавьсан. Мөн ОХУ-ын Красноярск хязгаар Залуу удирдагч форумын тайланг тавьсан. Дараагаар нь БНХАУ-ын Хэнан, Шаньдун муж, БНСУ-ын Гванжү хот, Гёнсанбүг муж, ОХУ-ын Амур муж тус тус орон нутгийнхаа талаар илтгэл тавьсан.

ОХУ-ын Сахагийн БНУ 2020 онд болох 13-р Бүгд хурлаар NEAR-ын гишүүн орон нутгууд хооронд бизнес хөгжүүлэх болон эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны зорилго бүхий хөрөнгө оруулалт, экспорт, аялал жуулчлалын сэдэвт танилцуулга тавихыг санал болгосон бөгөөд NEAR-ын Хэрэг эрхлэх газар үүнийг нь сонирхож буй орон нутгууд өргөнөөр оролцохыг хүссэн.

Хурлын 2-р хэсэгт Холбооны гол арга хэмжээг зохион байгуулах арга барилыг сайжруулах тухай санал, гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах, гишүүн орон нутаг бүрээр хүндэт элч томилох, 2020 оны ЗХАНЗХ-ны Хэрэг эрхлэх газрын арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах болон төлөвлөгөөний талаар гишүүн орон нутгуудын саналыг авах зэрэг 4 санал оруулсныг хэлэлцэж дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

1. Холбооны арга хэмжээг сайжруулах арга зам

Тус Холбоо цар хүрээний хувьд өргөжин тэлэхийн хэрээр гарах болсон асуудал тухайлбал хурлаар хэлэлцэх асуудал болон асуудал хэлэлцэх цаг хугацааг урьдаас тохирдоггүй, орчуулгын чанар хурдаас шалтгаалан илтгэл, хэлэлцүүлгийн агуулгыг бүрэн гүйцэд ойлгоход бэрхшээл гардаг асуудлыг засч сайжруулах үүднээс дараах зүйлийг тохиролцсон.

Нэгдүгээрт, Ажлын хэсгийн хорооны хурал, Салбар хороодын хурал, Гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, NEAR-ын Олон улсын форум зэрэг Холбооны арга хэмжээг зохион байгуулахад арга хэмжээг зохион байгуулагч орон нутаг нь Холбооны арга хэмжээ болох хугацаа, хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан

танилцуулах ба арга хэмжээ зохион байгуулах орон нутаг нь арга хэмжээ болох хугацаа, сэдэв, болох газар зэргийг товлон дор хаяж 3 сарын өмнөөс урилгын хамт зар бичгийг NEAR-ын ХЭГ-т явуулах ба NEAR-ын ХЭГ-аас үүнийг нягталж үзсэний дараа нийт гишүүн орон нутгууд руу явуулна.

Хоёрдугаарт, Зохион байгуулагч тал хурал, арга хэмжээний бэлтгэлийг хангах шаардлагатай тул арга хэмжээнд оролцох орон нутаг 2 сарын өмнөөс оролцох хүмүүсийн нэрс, холбогдох мэдээллийг NEAR ХЭГ-т явуулна. Илтгэлд орох материалыг хурал болохоос 1 сарын өмнө, илтгэлийн сценарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө NEAR-ын ХЭГ-т илгээнэ. Гэхдээ, дээрх асуудлыг сайжруулах тухай тавьсан санал нь Холбооны арга хэмжээнд оролцох байдлыг нэмэгдүүлэх, хурлын ажиллагааг саадгүй явуулахын тулд гаргасан санал бөгөөд хүчээр тулгаж шаардсан зүйл биш гэдгийг бататгасан.

2. Гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах

2016 оны 11-р Бүгд хурлаар NEAR Холбооны гишүүний татварын журмыг баталж гишүүний татвар төлөх тогтолцоог нэвтрүүлэх шийдвэр гарсан ч одоог хүртэл гишүүн орон нутгуудын дийлэнх нь гишүүний татвар төлөх талаар сөрөг байр суурьтай байгаа тул NEAR-ын ХЭГ-ийн төсвийн зарцуулалтын талаарх итгэлцэл бүрдэж, гишүүний татварын зарцуулалтын талаар тохиролцож гишүүний татвар төлөх нийтлэг ойлголттой болох хүртэл гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулахаар болж үүнтэй холбогдуулан гишүүний татварын журмын агуулгад нэмэлт өөрчлөлт оруулсан.

3. Гишүүн орон нутаг бүрээр хүндэт элч томилох

Гишүүн улс, орон нутгийн Холбооны талаарх ойлголтыг нэмэгдүүлж, гишүүн орон нутагтаа манлайлах нөлөөлөх хүмүүсийг гишүүн орон нутгуудаас NEAR-ыг сурталчлах хүндэт элчээр томилохоор болсон. Хүндэт элч нь тухайн гишүүн орон нутагтай нягт харилцаатай байж хэвлэл мэдээлэлд нийтлэл тавих, илтгэл лекц тавих, гишүүн орон нутгуудын олон улсын харилцааны арга хэмжээнд идэвхтэй оролцож NEAR-ыг сурталчлах үйл ажиллагааг өрнүүлэх ба хүндэт элчийг томилох хугацаа, бүрэлдэхүүн, үүрэгт хугацаа зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг NEAR-ын ХЭГ-аас бичгээр гишүүн орон нутгуудад хүргэнэ.

4. NEAR-ын ХЭГ –аас зохион байгуулах 2020 оны арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах болон гишүүн орон нутгуудын саналыг тусгах

NEAR-ын ХЭГ нь NEAR-ын Олон улсын форум, Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, Зүүн хойд Азийн залуу удирдагч форум зэрэг 2020 онд зохиох гол арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулж, уг төлөвлөгөөний талаар гишүүн орон нутгуудын саналыг авч, арга хэмжээ зохион байгуулахад тусгаж байхаар болсон.

Үүнээс гадна энэ удаагийн Ажлын хэсгийн хорооны хурлаар Холбооны 14-р Бүгд хурлыг зохион байгуулах орон нутаг гараагүй тул 13-р Бүгд хурал болохын өмнөх хүртэл хүсэлт хүлээж авахаар болсон бөгөөд NEAR-ын ХЭГ-аас анх удаа төсвийн зарцуулалтын талаар дэлгэрэнгүй тайлан тавьсан бөгөөд хуралд оролцсон орон нутгийн төлөөллүүд NEAR-ын ХЭГ байгуулагдсанаас хойш тус газрын үйл ажиллагааны зардлыг бүхэлд нь хариуцаж байгаа БНСУ-ын Гёнсанбүг мужид талархал илэрхийлсэн.

Гишүүн орон нутгууд энэ удаагийн Ажлын хэсгийн хорооны 12-р хурлаар Холбооны арга хэмжээ зохион байгуулах арга барилыг сайжруулан гишүүн орон нутгууд Холбооны олон улсын харилцааны үйл ажиллагааг улам идэвхжүүлж, Холбооны талаарх сурталчилгааны үйл ажиллагааг бэхжүүлж Холбооны нэр хүндийг дээшлүүлэхээр болсон.

2019 оны 08 сарын 07-ны өдөр